



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№47 /491/

2023.03.21

Цаг үе, үйл явдал

## БНТУ-Д ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН АЛБА ХААГЧДАД ТӨРИЙН МЕДАЛЬ ГАРДУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх БНТУ-д эрэн хайх, аврах, эмнэлэг, хүмүүнлэгийн тусламжийн үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд төрийн медаль гардуулав.

Төр, засгийн өгсөн үүрэг, даалгаврыг нэр төртэй, мэргэжлийн өндөр түвшинд биелүүлсэн 35

алба хаагчийг "Шударга журам", "Цэргийн хүндэт" болон "Энхийн төлөө" медалиар шагналаа.

Цаг агаарын хүнд нөхцөл, газар хөдлөлтийн байнгын аюул, эрсдэлийн дор өндөр зохион байгуулалттай, чадварлаг ажиллаж, олон хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалсан бие бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт

хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх талархал илэрхийлээд онцгой хариуцлагатай, нэр хүндтэй албанд хүчин зүтгэж байгаа алба хаагчид болон тэдний гэр бүл, үр хүүхдүүд, хөдөлмөрийн хамт олонд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөлөө.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	24

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,525	3,531
EUR	3,782	3,795
CNY	514	515
RUB	44.80	45.50
JPY	26.85	27
KRW	2.70	2.71

### ЗУРХАЙ




**ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР**  
**НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Сүлд тэнэж одно  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
06.54-19.05  
**Барилдлага:**  
Арвидах  
**Шүтэн барилдлага:**  
Төрөхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

## "МХЗЭ 100, 101 ЖИЛ" НОМЫГ ОЛНЫ ХҮРТЭЭЛ БОЛГОЛОО



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойн босгон дээр Ардын Армийн ХЗЭ-ийн ахмад ажилтнууд цэргийн доторх ХЗЭ-ийн байгууллагын үүсэл, хөгжил, түүхэн уламжлал, батлан хамгаалах хүчийг бэхжүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг, оруулсан хувь нэмрийг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, сурталчлан таниулах зорилгоор "МХЗЭ 100, 101 жил" сэдэвт номыг бүтээж, үзэгч олны хүртээл болголоо.

Номын нээлтийн ажиллагаанд МАА-ийн Улс төрийн газрын Эвлэлийн байгууллагын хэлтсийн даргаар ажиллаж байсан чөлөөнд байгаа хурандаа Г.Буянхишиг, Д.Эрдэнэдаш, Д.Нямбаяр, Ц.Цэвээнсүрэн, Улаанбаатар хотын ХЗЭ-ийн

хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга асан, МХЗЭ-ийн ахмад ажилтнуудын холбооны тэргүүн, доктор, профессор Б.Энхмандах, Шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор, профессор, хошууч генерал Н.Жалбажав, МХЗЭ-ийн ахмад ажилтан, доктор, профессор, хурандаа Х.Шагдар, номын санаачлагч хошууч генерал Г.Дугарсүрэн агсны охин Оюунцэцэг, ЦНДС-ийн хангалт үйлчилгээний ротын ХЗЭ-ийн үүрийн дарга асан, Соёлын гавьяат зүтгэлтэн Ш.Ёолк, "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл" ТББ-ын тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа, Армийн нэгтгэл ангиудад улс төрийн хэлтсийн ХЗЭ-ийн ажлын туслахаар ажиллаж байсан ажилтан, алба

хаагчид оролцсон юм.  
Энэ үеэр уг номын эхийг бэлтгэж хэвлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлсэн бэлтгэл хошууч Л.Эрдэнэбаатарыг Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар, бэлтгэл хурандаа Ц.Цэвээнсүрэнг БХЯ-ны Ахмадын хорооны Хүндэт тэмдгээр тус тус шагналаа.  
Түүнчлэн Армийн Улс төрийн газрын Эвлэлийн байгууллагын хэлтсийн дарга асан чөлөөнд байгаа хурандаа Д.Нямбаяр армийн эвлэлийн байгууллагын түүх мөнхөлж ном бүтээсэн ажилтнууддаа талархал илэрхийлж хэвлэлийн зардалд хагас сая төгрөг хандив өргөсөн юм.

### ЭЭРЭГ

ҮБХИС-ийн Харуул үйлчилгээний ротын ХЦАХ-чид орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, Монгол цэргийн өдрөөр төрсөн өдөр нь тохиосон түрүүч, байлдагч нарынхаа баярыг тэмдэглэн өнгөрүүлжээ.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 682,597,364

Эдгэрсэн

Нийт: 655,536,882

Нас барсан

Нийт: 6,820,352

Цахим шууданд

# ДАЙЧИД МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙГЭЭР ЗОЧИЛОО



**Зэвсэгт хүчний 015 дугаар анги**  
Монгол цэргийн баярыг тохиолдуулан Монголын төр, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн түүх, үе үеийн эх орончдын байгуулсан гавьяаг сурталчлан таниулах зорилгоор хугацаат цэргийн алба хаагчдаа

Монгол цэргийн музейгээр аялууллаа. Эл арга хэмжээний хүрээнд ХЦАХ-д Монгол цэргийн музейн голлох үзвэрийн танхимууд болох Эртний түүхийн танхим, Цэргийн төрөл мэргэжлийн танхим, Хүндэтгэлийн танхим, Гадна ил талбайн гэсэн 4 үзвэрийн танхимыг тайлбартайгаар

үзэж сонирхон мэдлэг, оюундаа хөрөнгө оруулалт хийсэн юм. Мөн энэ үеэр Захирагчийн сургалт бэлтгэл хариуцсан орлогч дэд хурандаа Э.Хадбаатар цэргүүдэд энхийг сахиулагчидтай холбоотой сэдвээр ярилцлага хийж сонирхолтой яриаг өрнүүлээ.

## ГАРДАН ТУЛААНЫ ТЭМЦЭЭН БОЛЛОО



**Зэвсэгт хүчний 150 дугаар анги**  
Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан ангийн аварга шалгаруулах "Гардан тулаан"-ны зэвсэгтэй, зэвсэггүй катаны тэмцээнийг зохион байгууллаа.  
Тэмцээнд 11 багийн 70 гаруй тамирчин

өрсөлдсөнөөс тэргүүн байрт ахлагч А.Отгонпүрэв ахлагчтай байлдааны хангалтын салбар 312 оноогоор, дэд байрт ахлах ахлагч Г.Мөнхболор ахлагчтай нэгдүгээр мотобуудлагын ротын нэгдүгээр салаа 297 оноогоор, гутгаар байрт ахлах ахлагч О.Балжинням ахлагчтай миномётын батарейны хамт олон тус тус шалгарч бусад нөхдөө манлайллаа.

## ЁСЛОЛЫН ЖАГСААЛААР...



Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Нийслэлийн Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 102 жилийн ойд зориулсан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын "Ёслолын жагсаал"-ыг Д.Нацагдоржийн талбайд зохион байгууллаа.  
Баярын арга хэмжээний үеэр 10 гаруй алба хаагчид салбарын шагнал болоод Засаг даргын баярын бичиг,

Цэргийн цолоор шагнагдсаныг дүүргийн удирдлагууд гардуулан өгч, баяр хүргэлээ.  
Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 084-р ангийн шүхэрчин дайчдын "Гардан тулааны үзүүлэх тоглолт" болон Тусгай хүчний цэргийн "Буудлагын зэвсэг, тусгай хэрэгслийн үзэсгэлэн"-г дүүргийн ард, иргэд хүүхэд залуучуудад үзэж сонирхлоо.  
**БАГАНУУР ДҮҮРГИЙН  
ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ**



## "СОЁМБО" ПОДКАСТ...



Батлан хамгаалах бодлого, зорилтыг иргэд олон нийтэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд БХЯ-ны "Соёмбо редакц"-аас эрхлэн гаргаж буй "Соёмбо подкаст"-ын анхны дугаар үзэгч олон нийтэд хүрэхэд бэлэн боллоо.  
Манай "Соёмбо подкаст"-ын анхны дугаарын хөтөч сэтгүүлчээр "Их засаг" лицей сургуулийн 12

дугаар ангийн сурагч Эрдэнэчулууны Содбилэг, зочин оролцогчоор Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Артиллерийн дивизионы тийрэлтэт артиллерийн батарейны байлдагч Ган-Эрдэнийн Төгөлдөр нар уригдан оролцож сонирхолтой яриа өрнүүлснийг та бүхэн "Соёмбо редакц", "Дуулга студи" фейсбүүк хуудас болон Youtube сувгаас хүлээн авч үзээрэй.

## ТҮҮХЭН ҮЗМЭРҮҮДИЙН АНХНЫ ЗОЧИД БОЛЛОО



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-г тохиолдуулан ҮБХИС-ийн Харуул үйлчилгээний ротоос хугацаат албаны түрүүч, байлдагч нартаа Монгол Улсын баатруудын алдар гавьяаг мөнхжүүлэх, цэрэг эх оронч үзэл төлөвлөлийг бий болгох, үндэсний түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах, хүндэтгэн дээдлэх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор

"Монгол цэргийн музей"-н сан хөмрөгт шинээр дэлгэгдэж буй түүхэн баримт, үзвэрүүдтэй танилцууллаа.  
Түүнчлэн ҮБХИС-ын Харуул үйлчилгээний ротын бие бүрэлдэхүүн хугацаат цэргийн алба хаагчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар цэрэг дайчдынхаа албандаа хандах хандлагыг дээшлүүлэх зорилгоор "Баян боол" МУСК-г үзүүлээ.  
**Ахмад Д.ГАНЦЭЦЭГ**

## "ДИЗЕЛЬ ХӨДӨЛГҮҮР" ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ЭХЛҮҮЛЭЭ



Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудад "Дизель хөдөлгүүр" төсөл хэрэгжиж эхэллээ. Энэ нь олон жил ашиглагдсан бензин хөдөлгүүрт цэргийн зэвсэглэл, техникийг дизель хөдөлгүүр болгон шинэчлэх ажил бөгөөд үүний эхлэл болгож Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн "ЗИЛ-131" загварын автомашинд туршилт судалгааны ажлыг эхлүүлсэн юм.  
Туршилтыг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Материал техникийн хэлтсийн Авто техникийн засвар, ашиглалтын офицер, хошууч Л.Уянбаатар, бэлтгэл хошууч С.Даарийбаатар тэргүүтэй бүрэлдэхүүн амжилттай гүйцэтгэсэнээ "Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчний 102 жилийн ойн баярын өдөр танилцуулав.  
Хуурай замын цэргийн

командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал "Энэхүү төсөл нь цэргийн зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх, маневр болон хүчин чадал, нөөц явалтыг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээ хийхэд сэлбэг хэрэгслийн олдоц нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой. Улс орны эдийн засаг хүндрэлтэй, төсөв байхгүй гээд гараа хумиад суух биш өөрсдийн нөөц бололцоо, туршлага чадварт суурилж, зарим зэвсэглэл, техникээ энэ зарчмаар шинэчлэх нь бидний зорилт" гээд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаярт шинэчлэгдсэн "ЗИЛ-131" автомашиныг хүлээлгэн өгсөн юм.  
"Дизель хөдөлгүүр" төсөл Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудад хэрэгжихээр төлөвлөгдсөн ба эхний туршилт ийнхүү амжилттай болсон юм.  
**Ахмад Д.БОЛОР**